## ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

**Говь.Алтай аймаг**

**Огноо: 2025.12.03**

| № | Гэрээний дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2025 оны төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Зарцуулсан хөрөнгө /мян.төг/ | Хөрөнгийн эх үүсвэр | Аймгийн Засаг дарга, Тамгын газар болон бусад байгууллагын зүгээс хэрэгжүүлэхэд оролцсон тайлан | тайлбар | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | | | | | | |
| 1 | 3.1.1. | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах | - | Угийн бичгийн хөтлөлтийн хувь | аймгийнх 2024 онд 56.1% | Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна. | 60% | 20,000.0 | хувийн хэвшил | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Угийн бичиг-Удмын хэлхээ 2024-2028" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, аймгийн 18 сум, 2 тосгоны хэмжээнд угийн бичиг хөтлөлтийн ач холбогдол болон шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гэрийн угийн бичгээ хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр нийт 250 сургагч багшийг бэлтгэж, сум бүрт ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Хөдөлгөөний хүрээнд 18 сум, 2 тосгонд бүсчилсэн хэлбэрээр ажиллаж, орон нутгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, угийн бичгийн үзэсгэлэнгэй танилцлаа. Олон нийтэд цус ойртолтын хор уршиг болон гэрийн бичгээ шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлөн үр хойчдоо өвлүүлэн үлдээх ач холбогдлыг таниулах, угийн бичиг хөтлөлтөөрөө аймагтаа тэргүүлж буй сум, байгууллагын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой 1 нэвтрүүлэг, 2 контентыг бэлтгэн олон нийтэд хүргэлээ. Мөн аймгийн хэмжээнд "Шилдэг угийн бичиг 2025" уралдааныг зохион байгуулж, 9 шилдэг угийн бичгийг шалгаруулж, улсын уралдаанд оролцуулахаар боллоо. Угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлыг таниулах 235 удаагийн сургалтыг зохион байгуулж, 12748 насанд хүрэгч, 1028 хүүхэд нийт 13776 хүнийг хамруулалаа. Аймгийн 9924 өрх угийн бичгээ хөтөлж, нийт угийн бичиг хөтлөлтийн хувь 60%-тай байна. | | 100 |
| **3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:** | | | | | | | | | | | | |
| 2 | 3.1.2.1. | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 22,500.0 | 1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1<br>2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь | 2024 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг-13, зөрчил 96 | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | төлөвлөгөөний хэрэгжилт 100% | 5,507.0 | УТ | Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хуулиар үүрэг хүлээсэн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжил арга зүй удирдлагаар хангах чиглэлээр нийт 12 төрлийн ажил, арга хэмжээг тусгаж, бүрэн хэрэгжүүллээ. Аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 19, зөрчил 72 бүртгэгдэж, дуудлага мэдээллийн дагуу хамтарсан баг хариу үйлчилгээг үзүүлэн ажилллалаа. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 26 удаагийн албадан сургалтад 100 иргэн хамрагдлаа. Есөнбулаг сумын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, кейс менежментийн арга зүй олгох сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөөх "Галт шувуу" НҮТББ-тай хамтран зохион байгуулж, нийт 60 гишүүнийг хамрууллаа. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил давтан үйлдсэн, архинд донтох эмгэгтэй 15 гэр бүлийн 20 гишүүдэд Баянхонгор аймгийн "Жаргалтай амьдрал" төвийн мэргэжлийн багтай хамтран "Өөрийгөө өөрчилье" 4 өдрийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, бүлгийн болон ганцаарчилсан, хосын сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүллээ. Архинд донтох эмгэгтэй 2 иргэнийг аймгийн Цагдаагийн газартай хамтран албадан эмчилгээнд хамрууллаа. | | 100 |
| 3 | 3.1.2.2. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь | 56 удаагийн сургалт нөлөөллийн ажилд 2466 хүнийг хамруулсан. | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ | 10,530.0 | УТ | Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн зөрэг харицааг бий болгох, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, өрх бүр угийн бичиг хөтлөх, гэр бүлийн боловсролоор дамжуулан гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог бэхжүүлэх зорилгоор "Гэр бүл–Гэрэлт ирээдүй" сарын аянг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 17 төрлийн арга хэмжээнд 3260, гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 6532 хүнийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 3470 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд 9792 иргэн хамрагдсанаас 2500 нь гэр бүл байна. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 3.1.2.3. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Сэтгэл зүйн тусламж,үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | 113 | Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна | нийт өрхийн 15.2% | 10,550.0 | УТ | "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-ийн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хүүхэд 91, насанд хүрэгч 62 нийт 153 хүнийг хамруулаа. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 26 удаагийн албадан сургалтад 100 иргэнийг, "Хоригдол суллахад бэлтгэх хөтөлбөр"-т тусгагдсан арга хэмжээний хүрээнд 10 удаагийн сургалт, 23 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ нийт 33 удаагийн үйл ажиллагааг 7 хоног бүр 4 хоригдолд үзүүлэн ажиллалаа. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 2026 онд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв ажиллуулах заавар зөвлөмжийг 18 сум, 2 тосгоны хэмжээнд танилцуулж, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажил үйлчилгээний орон нутгийн зураглалыг гаргах, хүний нөөц, санхүүгийн нөөцийг тодорхойлох ажлыг зохион байгууллаа. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 2500 гэр бүл, 9792 иргэнийг хамруулсан нь нийт өрхийн 15.2%-ийг эзэлж байна. | | 100 |
| 5 | 3.1.2.4. | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд батлагдсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар [illegible] | Орон нутгийн төсөв 119.0 сая төгрөг | 102,600.0 | УТ 10,000.0 ОНТ 92,600.0 | Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" буцалтгүй тусламжаар баригдсан "Түр хамгаалах байр"-ны барилгыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан ба аймгийн ИТХурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 21 тоот "Түр хамгаалах байр байгуулах тухай" тогтоолоор орон нутагт хүчирхийллийн хохирогчийг хамгаалах "Түр хамгаалах байр"-ыг шинээр байгууллаа. 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/44 тоот "Түр хамгаалах байрны бүтэц, орон тоо батлах тухай" аймгийн Засаг даргын захирамжаар нийт 5 орон тоог баталж /зохицуулагч-1, нийгмийн ажилтан-2, сэтгэл зүйч-1, тогооч, үйлчлэгч-1/, одоогоор зохицуулагч-1, нийгмийн ажилтан-2, тогооч үйлчлэгч-1 нийт 4 хүн ажиллаж байна. Түр хамгаалах байрны урсгал зардал болон гэр бүлийн хүчирхийллийн насанд хүрсэн хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт тусгасны дагуу 119.0 сая төгрөгийг шийдвэрлэлээ. 2025 оны 11 сарын байдлаар "Түр хамгаалах байр"-нд хүүхэд 25, насанд хүрэгч 7 нийт 32 хүнийг аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээг төлөвлөн үзүүлж, хохирогчийг гэр бүлд нь эргэн нэгтгэж ажиллалаа. | | 100 |
| | | НИЙТ | | | | | | 149,187.00 | | | | |
| 3.1.3. Хүүхдийн эрхийн талаар: | | | | | | | | | | | | |
| 6 | 3.1.3.1. | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх; | | 1.Төлөвлөгөө батлагдсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 98 | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | төлөвлөгөөний хэрэгжилт 100% | 2,500.0 | УТ | Хүүхдийн төлөө зөвлөлөөс хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилт 100%-тай байна. Тус зөвлөл хүүхдийн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх, "Засагт ханы хот айл" гэр зуслан ажиллуулах, "Хамтын шийдэл-хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөтөлбөр батлуулах, аймгийн хүүхэд, гэр бүлийн чиглэлээр орон нутагт хийж буй ажлын үр дүн, зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гишүүн байгууллагуудын мэдээлэл зэрэг асуудлуудыг хэлэлцлээ. Мөн тус зөвлөлөөс спорт, урлаг, уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулах асуудлыг хэлэлцэн баталж, уг арга хэмжээнд 166 хүүхдэд 268,0 сая төгрөг олголоо. | | 100 |
| 7 | 3.1.3.2. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх; | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | 2024 онд 950 хүүхэд хамрагдсан | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна. | 25.5%-иар өссөн | 355,329.4 | Улсын төсөв-77,329.4 ОНТ-268,000.0 Хувийн хэвшил - 10,000.0 | Урлаг, соёл, спортын 26 төрлөөр 2024-2025 онд амжилт гаргасан 166 хүүхдийг 268,0 сая төгрөгөөр орон нутгаас шагнаж урамшууллаа. Мөн хүүхдийн хөгжил, оролцоог сайжруулах чиглэлээр "Дэлхийн зөн" олон улсын байгууллага, "Нар хүссэн яргуй" ТББ, "Юнител" групптэй тогтмол хамтран ажиллаж байна. Хүүхэд залуучуудын ордонд 11 төрлийн сургалт, дугуйланд 356 хүүхэд хамрагдаж байна. "Юнител" группээс "unitel steam hub"-ын сургалтын төрлийг нэмэгдүүлэн 10.0 сая төгрөгөөр сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг олголоо. ХХҮГ-аас ахмад настны зөвлөх үйлчилгээний хүрээнд аймгийн хэмжээнд 43 ахмад багш нар хүүхдийг хөгжлийг дэмжих, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр 21 төрлийн сургалт, дугуйлан зохион байгуулж, 250 хүүхэд хамрагдлаа. Аймгийн хэмжээнд нийт 40 орчим дугуйланд 600 гаруй хүүхэд хамрагдаж байна. 2025 онд хүүхдийн 12 төрлийн сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 9562 хүүхэд хамрагдаж, 28 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж нийт 1403 хүүхэд оролцлоо. Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 25.5 хувиар өссөн байна. | | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 3.1.3.3. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах; | 1,684,863.6 | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | 100%-тай хэрэгжсэн байна. | 3,492.0 | УТ 1,210.0 ОНТ 2,282.0 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих төлөвлөгөөг 4 зорилт, 33 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, биелэлт 100%-тай байна. Сум, багуудад шинээр томилогдсон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 14 хүнийг хамруулан бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар сургалт, мэдээллийг өглөө. Мөн сургуулийн өмнөх боловсролд хүүхэд нь суралцдаг 250 эцэг эхэд бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар сургалт зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 138 "Эцэг эхийн зөвлөл" ажиллаж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийн өрөөтэй байгууллага 18 байна. "Эцэг эхийн зөвлөл"-үүд нь гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг нийт 2877 хүнийг хамруулан зохион байгууллаа. Бага насны хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор "Цодгор хүү", "Уран жиргээ" тэмцээнүүдийг зохион байгуулж, 3.4 сая төгрөг зарцууллаа. Цогц үзлэгт 9 сартай хүүхдийн 33.9%, 18 сартай хүүхдийн 23.7%, 36 сартай хүүхдийн 21.8%-ийг хамруулж, 0-1 хүртэлх насны 897 хүүхдийн 73.2%-ийг гэрийн эргэлтэд хамрууллаа. Өндөр тунт А аминдэмээр 6-11 сартай 522 хүүхдийн 96.3%-ийг хангалаа. Сургуулийн өмнөх боловсролын 31 цэцэрлэгийн 172 бүлэгт 4112 хүүхэд хүмүүжиж байгаагаас 3761 нь цэцэрлэгийн үндсэн бүлгээр, 351 нь хувилбарт сургалтаар суралцаж байна. Энэ хичээлийн жилд 1401 хүүхэд шинээр элсэж, халамж эдэлдэг 27, хөгжлийн бэрхшээлтэй 21, бүтэн өнчин 1, хагас өнчин 39 хүүхэд хүмүүжиж байна. Сургуулийн өмнөх боловсролын өдрийн ангийн бүлэг дүүргэлт 25 болж өмнөх оноос 1-ээр буурсан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/569 тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.4.2. дахь заалтын норм нормативыг бүрэн хангалаа. | 100 |
| 9 | 3.1.3.4. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах; | | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо 2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | | | | Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан тендэр шалгаруулалтад тэнцсэн компанийг хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээг нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг чиглэл болгон ажиллаж байна. | - |
| 10 | 3.1.3.5. | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах; | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | - | Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна. | 100% | УТ-5000, ОНТ-56,700.0 | УТ | Хүүхдийн зөвлөл, оролцооны байгууллага, клубүүдийн үйл ажиллагааг бэхжүүлж, арга зүй удирдлагаар хангаж ажиллаж байна."Өсвөр үе-Эрүүл мэнд","Бяцхан алхам-том өөрчлөлт","Сургуулийн орчин дахь асуудал", "Мэдлэгээ хэрэглээ болгоё", "Үе тэнгийн сургагч багш бэлтгэх", "Youth power-Говь-Алтай" байгальд ээлтэй хүүхэд чуулган, "Хүүхэд-Хайр-Ирээдүй" зөвлөгөөн,"Хүүхэд, хүүхдэдээ зэрэгээр нөлөөлье" зэрэг 12 төрлийн сургалт, нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 4500 гаруй хүүхэд, насанд хүрэгчид хамрагдлаа.Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлыг хангах, өсвөрийн 18 клубт 270 гаруй хүүхэд хамрагдан, бусаддаа цахим орчны зөв зохистой хэрэглээний талаар мэдлэг, мэдээллийг түгээн ажиллаж байна.Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийг Хүүхэд залуучуудын ордонд өрөөтэй болгож тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангасан.Аймгийн Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Ээж ментор" сургалт нөлөөллийн үйл ажиллагааг 500 хүнийг хамруулан зохион байгуулахад 4.5 сая, "Ид шидийн орон" хүүхэд хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд 45.0 сая, скаутын холбоонд бүлгийн удирдагч бэлтгэх анхан шатны сургалтад оролцоход 3,4 сая, хүүхэд хөгжлийн "Майхант цугларалт" арга хэмжээнд оролцсон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлд 1,8 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар комисст 2,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. | 100 |
| 11 | 3.1.3.6. | "Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх. | | 1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | 1 | - | - | Аймгийн хэмжээний 18 сум, 2 тосгонд чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөн туслан ажиллаж байна. Энэ онд 5 сумд олон нийтийн байцаагч ажиллахаас Хөхморьт сумд олон нийтийн байцаагч ажиллаж байна. Эрсдэлт нөхцөл дэх 56 хүүхдийг шинээр илрүүлэн бүртгэж хамгааллын үйлчилгээ үзүүллээ.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 0.1 хувиар өссөн байна. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| НИИТ | | | | | | | | 418,421.4 | | | | |
| 3.1.4. Хүүхэд хамгааллын талаар: | | | | | | | | | | | | |
| 12 | 3.1.4.1. | "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх; | 450,292.9 | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна. | 130 | 500.0 | УТ | Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл"-үүд нь 2025 онд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг нийт 2877 хүнийг хамруулан зохион байгууллаа.<br>Аймгийн хэмжээнд нийт 138 "Эцэг эхийн зөвлөл" ажиллаж байгаагаас хүүхэд хамгааллын бодлоготой байгууллагын тоо 138. хүүхдийн өрөөтэй байгууллагын тоо 18 байна. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 40 байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн тусалж ажилллаа. | | 100 |
| 13 | 3.1.4.2. | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх; | | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | 921 | УТ-39808.7<br>ОНТ-24,100.0 | УТ, ОНТ | Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах "Хамтын шийдэл-Хамгаалагдсан ирээдүй" хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүллээ. Хүүхдийг ивээх сантай хамтран "Хүүхэд хамгааллын асуудал, шийдэл" чуулга уулзалтыг зохион байгуулж, 100 гаруй хүн оролцож, хамтран ажиллах бодлогоо тодорхойллоо. Эрсдэлийн программд 183 хүүхдийг шинээр бүртгэснээр программд нийт 921 хүүхэд бүртгэгдлээ. Хамгаалал шаардлагатай 2623 хүүхэд байгаагаас 280 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийн анхан шатны багц олгож, 543 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, 56 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд холбон зуучилж, хамтарсан багаар ажилллаа. Эрсдэлт нөхцөл дэх 56 хүүхдийг шинээр илрүүлэн бүртгэж хамгааллын үйлчилгээ үзүүлж, 566 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэн кейсийг хаасан. Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд 119 хүүхэд үрчлэгдсэн бөгөөд 2025 онд 15 хүүхэд үрчлэгдсэн байна. Аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран "Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой"-н хүрээнд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж, "Макс" группээс бүтэн өнчин 16 хүүхдэд хадгаламж гардууллаа. Аймгийн Засаг дарга хүүхдийн баяраар Есөнбулаг сумын бүтэн өнчин 16 хүүхдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, уулзалт ярилцлага зохион байгуулж санал бодлыг нь сонсч, бүтэн өнчин 29 хүүхдэд 16.5 сая төгрөгийн хувцас, хичээлийн хэрэгслээр хангаж, 2 хүүхдэд сургалтын төлбөрийн дэмжлэг өглөө. Мөн бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж мэдээллийн санд бүртгэх ажлыг хийлээ. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Нэгдсэн эмнэлэгт шинээр төрсөн 17 эх, нярайд хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг, хүүхдийн тасагт хэвтэж бсан 13 хүүхдэд бэлэг өглөө. Эрсдэлт нөхцөл дэх 3853 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүллээ. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 26662 хүүхэд оролцсон бөгөөд кейс менежментийн үйлчилгээнд эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн 83 хувь нь хамрагдан хамгааллын үйлчилгээ авсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд 39.8 сая төгрөгийг зарцууллаа. | | 100 |
| 14 | 3.1.4.3. | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлаж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх; | | 1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 26.7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | 100% | 1,263.00 | УТ | Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 46 дугаар захирамжаар аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 13 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлийн хүрээнд 28 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Тус хороо нь төлөвлөгөөт хурлыг 2 удаа, шуурхай хурлыг 1 удаа зохион байгууллаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг 28 хүүхдэд үзүүлж, 5 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна. Нөхцөл байлын үнэлгээ-5, аюулгүй байдлыг хангах-2, сэтгэл зүйн зөвлөгөө-19, хууль эрх зүйн зөвлөгөө-12, амьдрах ухааны болон эрүүл мэндийн сургалт-23, өмгөөллийн үйлчилгээ-3, шууд туслалцаа-8 хүүхдэд үзүүлэн ажиллаж байна.<br>Хүүхэд хамгааллын зардлаас 1263.0 мянган төгрөгийн хамгааллын хариу үйлчилгээг үзүүллээ. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | 3.1.4.4. | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих; | | 1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | 98% | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | 100% | 3,908.1 | УТ | Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажиллах талаар Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмжийг 18 сум, 2 тосгоны Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн бөгөөд Засаг дарга, уяачдын холбоонд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тогтоол зөрчиж уралдаан зохион байгуулсан 2 иргэнд зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцлоо. Аймгийн баяр наадамд 9 насны 347 морийг 116 хүүхэд, "Алтайн хавар-2025" аймгийн бүсийн хурдан морины 8 насны уралдаанд нийт 843 морийг 481 уралдаанч хүүхэд, Тайшир шохойн үйлдвэрийн нээлтэд зориулсан уралдаанд 2 насны морины уралдаанд 45 морийг 18 хүүхэд, Алтайн шигшмэл хурд уралдаанд 9 насны 178 морийг 93 хүүхэд унаж уралдсан. Аймгийн хэмжээний томоохон 4 удаагийн уралдаанд 1413 морийг 708 уралдаанч хүүхэд унаж уралдууллаа. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж 100 хувь хамгаалалтын хувцас өмсүүлэн, 100 хувь даатгалд хамруулсан бөгөөд 15 хүүхэд мориноос унаж эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн эцэг эх, асран хамгаалагчдад хүлээлгэн өглөө. | | 100 |
| 16 | 3.1.4.5. | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх; | | 1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | 1098 иргэнд мэдээлэл өгсөн. | 1961.0 | УТ | Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь 1 удаа хуралдаж төлөвлөгөөнд тодотгол хийж ажиллалаа. Мөн Гамшиг онцгой байдлын бэлэн байдлыг хангаж 2 удаа жагслаа. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сургуулийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийх, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, гамшигт өртсөн хүүхдүүдийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор байгалийн гамшиг тохиолдсон Эрдэнэ сумд 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эрсдэлт нөхцөл дэх хүүхэдтэй 7 өрхөөр орж нөхцөл байдалтай танилцаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын багц олгож зөвлөн туслан, асран хамгаалагчтай санал бодол солилцлоо. Эрдэнэ сумын сургуулийн нөхцөл байдалтай танилцлаа. Байгалийн гамшигт үзэгдэлд өртсөн 100 хүүхдийн судалгаа гаргаж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хамгаалал шаардлагатай 11 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. "Хамтдаа зүтгэе" уриан дор "Сэргээд мордъё", "Дүрмээ мөрдье", "Хүүхэд хамгаалал-2025" нэгдсэн арга хэмжээг аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч, зорчигчдыг сэргээх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг гэмт хэрэг, осолд өртөж хохирох, үер усны аюул, улаан бурхны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Говь-Алтай Ховд чиглэлийн А0304 улсын чанартай зам дагуу Шарга сумын Ээвийн буудлын зогсоол болон Дэлгэр сумын Цагдаагийн пост дээр зохион байгуулж иргэдэд кофе, цай, витаминаар 712 иргэнд, мөн гэмт хэрэг, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч, санамж, сэрэмжлүүлгийг 1098 иргэнд өгч ажиллалаа. Замын хөдөлгөөнд оролцохдоо хүүхдийг зориулалтын суудалд суулгасан, хамгаалах бүсийг зөв хэрэглэсэн 4 жолоочийг урамшууллаа. Мөн зорчигчдыг "Хүн бүр хүүхэд хамгаалагч" уриалгад нэгдүүлэн, хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг 30 иргэнд тус тус үзүүлж ажиллалаа. | | 100 |
| 17 | 3.1.4.6. | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх; | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | 0.2%-иар буурсан | 350.0 | УТ | Хүүхдийн тоглоомын талбай, аймгийн сум хийд, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд нийтдээ 6 удаа хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр зөвлөн тусалж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Аймгийн төвийн 5 тоглоомын талбайд засвар үйлчилгээ хийгдэж байна. Мөн аймгийн баяр наадам болон бүсийн хурдан морины уралдаанд нийтдээ 8 удаа уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж, цахим мэдээллийн санд бүртгэлийг хийх талаар зөвлөн тусалж ажиллалаа. Энэ онд хүүхдийн осол гэмтэл 13 гарсан ба өмнөх оноос 0.2%-иар буурлаа. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 3.1.4.7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах. | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | - | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна. | 0.1%-иар буурсан | 100.0 | УТ | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй "Итгэл", "Жаргалын төв" хүүхэд харах үйлчилгээнд нийт 5 хөгжлийн бэрхшээлтэй 13 энгийн хүүхэд хамрагдаж байна. Хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагаа, хүүхдийн ирц, бүртгэл, судалгаанд тогтмол хяналт тавин, хүүхдийн давхцалыг арилгах, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд хөгжүүлэх чиглэлийн ажлыг тогтмол зохион байгуулж, "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг танилцууллаа. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч нар үйлчилгээний байрны гадна орчноо тодорхой хэмжээнд тохижуулж эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, аюулгүй орчноо бүрдүүлсэн ба тоглоомын талбай байгуулаагүй байсан. Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй 2 сүм, хийдэд 1 удаа хяналт шалгалт хийлээ. Хүүхдийн эрхийн зөрчил гаргасан 3 иргэнд торгуулийн арга хэмжээ авсан.Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, Засаг дарга, аймаг сумын уяачдын холбоонд 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сургуулийн орчинд эрсдэлийн үнэлгээ хийх, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, гамшигт өртсөн хүүхдүүдийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор Эрдэнэ, Чандмань, Бугат сумдад 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эрсдэлт нөхцөл дэх хүүхэдтэй 7 өрхөөр орж нөхцөл байдалтай танилцаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын багц олгож зөвлөн туслан, асран хамгаалагчтай санал бодол солилцлоо. Эрдэнэ сумын сургуулийн нөхцөл байдалтай танилцаж эрсдэлт нөхцөл дэх хүүхэдтэй 4 өрхөөр орж нөхцөл байдалтай танилцаж, гэр бүлийн болон хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ажилтай танилцаж зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Хүүхдийн эрхийн зөрчил 0.1%-иар буурсан. | | 100 |
| | | **НИЙТ** | | | | | | **71,990.8** | | | | |
| **3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;** | | | | | | | | | | | | |
| **3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:** | | | | | | | | | | | | |
| 19 | 3.2.1.1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | | Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо | Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан. | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | 860 хүн хамрагдсан | 3,000.0 | УТ | Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлан таниулах, иргэдийн хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд "Цацрах мэлмий" ХХК, "Ундарга-Алтай" ААТҮГ, "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар", "Мэргэжлийн боловсролын сургууль", "АЗЗА ТӨХК", "Цаг уур орчны шинжилгээний газар", "Нийгмийн даатгалын газар", "Байгаль орчны газар"-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 155 ажилтан албан хаагч нарт сургалт, танин мэдэхүйн "Алтан хонх" тэмцээнийг зохион байгууллаа. Мөн Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй 16 байгууллага, аж ахуйн нэгжийн 330, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Баянтоорой, Цогт, Цээл сумдын 25 төсөвт байгууллагын 375, нийт 705 ажилтан албан хаагчдад "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн талаар сургалт зохион байгууллаа. Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор хөдөлмөрийн эрхийн маргаан, хөдөлмөрийн харилцаатай холбоотой 3 төрлийн 300 ширхэг гарын авлага боловсруулан иргэд олон нийтэд хүргэхээс гадна аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Байгаль орчны газрын албан хаагчдыг оролцуулан Хөдөлмөрийн тухай хуулиар асуулт хариултын богино хэмжээний видео бичлэг хийж, цахимаар сурталчиллаа. | | 100 |
| 20 | 3.2.1.2 | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | 2,074,121.9 | 1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо | - | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | 482 хүн хамрагдсан | | - | "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 50 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, 77 байгууллагад 1055 ажилтан байна. Дээрх аж ахуйн нэгжид хөдөлмөрийн харилцааны чиглэлээр сургалт зохион байгуулах, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэшүүлэх сургалтад эмгөөлөгч Б.Энхзаяаг хамрууллаа. Монгол улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль,Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэг олгох, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Дэвжээ" танин мэдэхүйн тэмцээнийг 2 үе шаттай, бүсчлэн зохион байгуулж, 23 сургуулийн 184 сурагч оролцлоо. Монгол улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх сургалтыг Есөнбулаг сумын 24 байгууллагын 482 ажилтан албан хаагчдад зохион байгуулж үүнээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын албан хаагчдад "Элсэн цаг" хууль эрх зүйн тэмцээнийг зохион байгуулж, Есөнбулаг сумын 8 цэцэрлэгийн 40 албан хаагч оролцлоо. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 3.2.1.3. | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | 3 | | - | Аймгийн Засаг даргын 2025 оны А/30 дугаар захирамжаар "Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо"-г шинэчлэн байгуулж, 1 удаагийн хуралдааныг зохион байгууллаа. Тус хороо нь 8 сумын 25 аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн маргаан таслах комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01/841 дугаартай удирдамжийн дагуу орон нутагт зохион байгуулсан улсын үзлэгтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны А/28 тоот "Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай" захирамжийг гаргасан. Тус захирамж болон хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг 18 сумын Засаг дарга нарт хүргүүлж, зөвлөн тусалж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар уул уурхайн салбарт 4, барилгын салбарт 4, төрийн байгууллагад 2, ачаа тээврийн салбарт 1 нийт 11 үйлдвэрийн осол гарч баталгаажсан байна. Хөдөлмөрийн 3 маргаан бүртгэгдэж, шийдвэрлэлээ. | | 100 |
| 22 | 3.2.1.4. | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах. | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | 3 | | - | Тайлант онд хамтын гэрээ, хэлэлцээрийг байгуулах, бүртгүүлэх чиглэлийн сургалт, зөвлөгөө мэдээлэлд 36 байгууллагыг хамруулаа. Үүнээс Есөнбулаг сумын 1-р цэцэрлэг, "Алтай-Улиастай" эрчим хүчний ТӨХК, Мэргэжлийн боловсролын сургуулийн "Хамтын гэрээ"-г бүртгэж баталгаажууллаа. | | 100 |
| | | **НИЙТ** | | | | | | **3,000.0** | | | | |
| | | | | | | | **3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:** | | | | | |
| 23 | 3.2.2.1. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | 1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | судалгаа хийсэн | | - | Аймгийн хэмжээнд 856 аж ахуйн нэгж байгууллагад 7657 ажилтан ажиллаж байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл Төсөвт байгууллага- 183, ХХК – 547, Хоршоо – 60, Нөхөрлөл – 16, Төрийн бус байгууллага -33, Холбоо- 6, Хувьцаат компани- 3, ОНӨААТҮГ-3, ТӨААТҮГ-5 байна. Үүнээс 1-4 ажилтантай 587 аж ахуйн нэгж байгууллагад 853 ажилтан, 5-24 ажиллагсадтай 192 аж ахуйн нэгж байгууллагад 2409 ажилтан, 25 ба түүнээс дээш ажиллагсадтай 77 аж ахуйн нэгж байгууллагад 4395 ажиллагсад байна. Орон нутгийн уул уурхайн компанитай хамтран ажиллаж, "Цэн газар" ХХК-ийн нийт 111 ажилтны 52 буюу 46.8 хувь, "Хан Алтай ресурс" ХХК -ийн нийт 1010 ажиллагсдын 370 буюу 36.7 хувийг орон нутгаас ажиллагсад эзэлж байна. Хөдөлмөрийн хяналтаар 2025 онд 30 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт, 3 чиглэлд урьдчилан сэргийлэх шалгалт, 1 баталгаажуулалтын арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн ажилласнаас 30 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт, 3 салбарын 24 аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт, 11 үйлдвэрийн осол хянан баталгаажуулалт хийж, 936 зөрчил, дутагдал илрүүлэн 26 аж ахуйн нэгж, байгууллагад 290 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 6 аж ахуйн нэгжид 9,2 сая төгрөгийн торгууль, шийтгэвэр, 52 аж ахуйн нэгж, байгууллагад 780 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | .. | | | | | | | | өрхөд 63.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, түүхий эд материалыг олгож, өрхийн үйлдвэрлэлийг дэмжлээ. | | 100 |
| 27 | 3.2.2.5. | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | 2,664,343.3 | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2.Холбогдох арга хэмжээний тоо | - | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. | | | | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Job center" төвийг дэмжих туршилтын төслийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудад дээрх төсөл болон "Хөдөлмөрийн хувийн бирж бүртгэж, санхүүжилт олгох журам"-ийн сургалтыг зохион байгууллаа. Үүний үр дүнд "Ирээдүйн иргэний хөгжил" НҮТББайгууллага хөдөлмөрийн хувийн биржийг байгуулсан. Тус биржээр дамжуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бэлтгэх ажлын хүрээнд 500 гаруй оюутан залууст мэдээлэл хүргэлээ. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 585 хүүхдэд мэргэжил сонголтын талаар, ажил хөдөлмөр эрхлээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй 381 орчим иргэнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг хүргэлээ.Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 374 байгууллага, аж ахуйн нэгжээс 1075 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу ажилгүй, ажил хайгч 850 иргэнийг ажилд зуучиллаа.Аймагт дэд бүтэц, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд болон томоохон бүтээн байгуулалтад орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлогыг баримтлан ажиллаж "Цэн газар" ХХК-ийн нийт 111 ажилтны 52 буюу 46.8 хувь, "Хан Алтай ресурс" ХХК -ийн нийт 1010 ажиллагсдын 370 буюу 36.7 хувь, "Мандал-Алтай" ХХК-ийн нийт 27 ажилтан 100 хувь, "Цэрдийн тал" ХХК-д 1, "Секэр ресурс" ХХК-д 3, аймгийн хэмжээнд нийт 453 орон нутгийн ажиллагсад эзэлж байна. | | 100 |
| 28 | 3.2.2.6. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | 1.Хяналт шалгалтын тоо<br>2.Судалгаа, мэдээллийн тоо<br>3.Холбогдох арга хэмжээний тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/<br>Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян.хүн /2023 он/ | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Хяналт шалгалт зохион байгуулж, эргэн төлөлт-95% | 79,200.0 | ХЭДС, Арилжааны банк | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд ажлын байр бий болгох, хадгалах зорилгоор ХААН банк, Төрийн банктай хамтран 34 аж ахуйн нэгж, иргэнд 1.1 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 34 ажлын байр бий боллоо. ХААН банк 28 аж ахуйн нэгж, иргэнд 875,0 сая төгрөг, Төрийн банк 6 иргэнд 225,0 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Зээлд хамрагдсан иргэдэд эдийн засгийн мэдлэг олгох, нэмэгдүүлэх зорилгоор эрх бүхий "Мэргэшсэн мэргэжил сургалтын төв"-тэй хамтран зээлийн өмнөх сургалтыг зохион байгууллаа.<br>Мөн зорилтот бүлгийн ажилгүй иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангаж, тогтвортой ажиллуулж байгаа ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг олгож байна. Тус арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн 10 иргэнийг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид 79,2 сая төгрөгийн урамшууллыг олголоо. Санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлэх, ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах зорилгоор улирал бүр "Эргэн төлөлт-2025" аяныг зохион байгуулснаар 647 иргэнээс 1140.0 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлж, эргэн төлөлтийн хувь 95 %-тай байна. | | 100 |
| 29 | 3.2.2.7. | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | 1.Холбогдох арга хэмжээний тоо<br>2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо | 2023 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна. | 18-34 хүртэлх насны 7 залуучууд хамрагдаж, ХЭДСангаас 80.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олголоо. | 80,000.0 | ХЭДС | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 18-34 хүртэлх насны 7 залуучууд хамрагдаж, ХЭДСангаас 80.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олголоо. Үүнд: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 18-34 хүртэлх насны залуучуудын дунд "Старт-Ап" арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 9 багийн 20 залуучууд бүртгүүлж 54 цагийн сургалт арга хэмжээнд оролцон, бизнес санаагаагаа танилцуулснаас Есөнбулаг сумын "Мазаалай", "Хөгжлийн соронз бүтээлч үйлдвэрлэл" багууд шалгарч, 36 сарын хугацаатай, 50 хувь нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 30.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгч 25-34 насны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 5 залуучуудад 36 сарын хугацаатай 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 50,0 сая төгрөгийг олголоо. "Старт-ап"-ын шилдэг 4 баг баруун бүсийн шилдэг "Старт-Ап" шалгаруулах арга хэмжээнд оролцсоноос "Цахилгаан хөдөлгүүрийн ороомог" 4-р байр, "Хөгжлийн соронз бүтээлч үйлдвэрлэл" 5-р байранд шалгарсан байна. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | 3.2.2.8. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах; | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан. | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | 12 иргэн хамрагдаж, 17.6 сая төгрөг | 31100,0 | ХЭДС | Орон нутгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр, нэг дороос борлуулах зорилгоор "Алтайд үйлдвэрлэв" борлуулалтын төвийг 2018 оноос хойш тасралтгүй ажиллуулж байна. Тайлант оны байдлаар "Алтайд үйлдвэрлэв" борлуулалтын 2 төвийг ажиллуулж, ажлын байрны түрээсийн төлбөрт 11.0 сая төгрөгийг зарцууллаа. Дээрх төвүүдээр нийт 21 аж ахуйн нэгж, иргэний 52 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж, зорилтот бүлгийн 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байна. Мөн ХЭДСангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 10 иргэнийг ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамруулж 6,6 сая төгрөгийг зарцууллаа. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе" үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж, 13,5 сая төгрөгийн борлуулалтыг хийлээ. | | 100 |
| 31 | 3.2.2.9. | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагаар дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | 3 удаа хуралдсан | | - | Аймгийн Засаг даргын 2025 оны А/129 дүгээр захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, 3 удаагийн хуралдааныг зохион байгуулж зөвлөлийн гишүүдийн чиг үүрэг, салбар зөвлөлийн дүрэм, 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, 2025 оны ХЭДСангийн гүйцэтгэл, ажлын тайлантай танилцаж мэргэжил арга зүйн дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа. Мөн 2026 онд ХЭДСангийн санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, өмнөх онуудад дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаатай танилцах хяналт хийх зөвлөмжийг хүргүүллээ. | | 100 |
| 32 | 3.2.2.10. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 108.9 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлсэн | | - | Аймгийн хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 77 аж ахуйн нэгж, байгууллага байна. Дээрх байгууллагуудад 148 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 168 ХБИргэн ажиллаж, 16 байгууллага 21 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаар байна. Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч 16 аж ахуйн нэгж, байгууллагад 153.4 сая төгрөгийн ажлын байрны төлбөрийн актыг хүргүүлснээс 3 байгууллагаас 108.9 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүллээ. | | 100 |
| **НИЙТ** | | | | | | | | **2,563,800.0** | | | | |
| **3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 3.2.3.1. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх | 2024 оны хэрэгжилт | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | 100% | | - | Энэ онд уул уурхайн салбарт 4, барилгын салбарт 4, төрийн байгууллагад 2, ачаа тээврийн салбарт 1 нийт 11 үйлдвэрлэлийн осол бүртгэгдэж баталгаажсан. Амь нас хохирсон осол байхгүй, хугарал, бяцралын төрлөөр 4, зөөлөн эдийн гэмтэл 3, хөнгөн гэмтэл 4 бүртгэгдсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиглэлээр "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил-Хиймэл оюуны хэрэглээ ба цахимжилт" уриатайгаар сарын аяны нээлтийг 04 дүгээр сарын 01-ний өдөр төв талбайд аймгийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон нутгийн зөвлөл"-тэй хамтран зохион байгууллаа. Аяны нээлтийн үеэр "Онцгой байдлын газар", "Хан-Алтай ресурс" ХХК, "Макс -Өргөө" ХХК, "Алтай Улиастай"ЭХТӨҮГазар ,Тайшир-Гуулин УЦС, Үндарга-Алтай ОНӨААТҮГазар, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, "Мандал-Голомт", Мэдээлэл холбоо сүлжээний газрууд ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм журам, техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа зэрэг салбар бүрийн аюулгүй ажиллагааны онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргаж, иргэд олон нийтэд сурталчлан таниуллаа. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, үйлдвэрлэлийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор эрчим хүч, дулаан үйлдвэрлэгч 17 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, инженер, техникийн 60 ажилчдад танхимын сургалт зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэшлийн сертификат олгох сургалтыг зохион байгуулж, аймаг, сумдын сургууль, цэцэрлэгийн ХАБЭА хариуцсан 132 албан хаагч хамрагдлаа. | | 100 |
| 34 | 3.2.3.2. | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Төлөвлөсөн төсөв 2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | | - | Аймгийн Засаг даргын 2025 оны А/29 дүгээр захирамжаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөлийг шинэчлэн байгууллаа. Тус зөвлөл нь 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, ХАБЭА-н сарын аяны төлөвлөгөө, тайланг хэлэлцлээ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 18 сум, 2 тосгонд сумын Засаг даргын захирамжаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг байгууллаа. Сумдын зөвлөлийн гишүүдээр дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, нийт 89 иргэнд сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Тус зөвлөл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг орон нутагт зохион байгуулсан дүн мэдээг хэлэлцэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар аймгийн Засаг даргын захирамж гаргах, сум байгууллагуудад хүргүүлж хяналт тавин ажилласан."Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа" аяны удирдамжийн хүрээнд ГХБХБГ, ХХҮГ-ын дарга нарын хамтран ажиллах төлөвлөгөө, хяналт шалгалт хийх, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх ажлын хуваарь зэргийг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу 4 барилга угсралтын талбайд ажиллан урьдчилан сэргийлэх шалгалт хийж, улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн, 40 ажилтанд сургалт мэдээлэл хийж ажиллав. Аяны нээлтийн арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, барилгын салбарын ХАБ хариуцсан ажилтан нарыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулан 23 хүнийг хамруулав. | | 100 |
| 35 | 3.2.3.3. | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг аврах хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Тухай бүр арга хэмжээ авсан байх | 9 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн | | - | Тайлант онд хүний амь нас эрсдсэн осол гараагүй, эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан 2 ослыг газар дээр нь очиж ажиллан, эрсдэл үнэлэх, бууруулах чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажилласан.Урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд 9 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 1 аж ахуйн нэгжид 1,0 сая төгрөгийн торгууль ногдуулж, бүрэн барагдуулан, 3,0 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт үйлдэж, барилгын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны чиглэлээр боловсруулсан улсын байцаагчийн 15 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх арга аргачлал, аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 95 ажилтан албан хаагчдад сургалт мэдээлэл өглөө. | | 100 |
| | | **НИЙТ** | | | | | | | | | | |

**3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:**

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 3.2.4.1. | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ 3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт | 2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн | Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | гадаад ажилтан байхгүй | | - | Монгол Улс, БНСУлсын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэл зохион байгуулах, зөвлөн чиглүүлэх ажлын хэсгийг байгуулж, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй байдлаар хүргэж, 02 дугаар сарын 20-21, 07 сарын 23-30-ны өдрүүдэд бүртгэлийг 2 удаа цахимаар зохисн байгууллаа. Тус шалгалтад орохоор 30 иргэн бүртгүүллээ. | | 100 |
| 37 | 3.2.4.2. | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | | | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | | | - | Аймгийн Боловсролын газарт 1 иргэн ажиллаж байгаад 8 сард оршин суух хугацаа нь дуусгавар болсноор нутаг буцсан байна. | | 100 |
| | **НИЙТ** | | | | | | | | | | | |
| **3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | | | | | | |
| **3.3.1. Нийгмийн даатгалын талаар:** | | | | | | | | | | | | |
| 38 | 3.3.1.1. | Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах; | | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он-152 800 | Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна. | 3452 | | УТ | Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран нийгмийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийн шинэчлэлийг сурталчлан таниулах соён гэгээрүүлэх ажлыг хамтран зохион байгууллаа. Алслагдсан сум, багийн иргэдийн нийтийн хурал, нийтийг хамарсан ажилд оролцох, нээлттэй хаалганы өдөрлөг, явуулын үйлчилгээ зохион байгуулж Сайн дурын даатгалын талаарх 58 төрлийн богино хэмжээний рийл, контент, шторк таниулга бэлтгэн цахим хэлбэрээр түгээж, 7 сумд хууль сурталчлах, нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг зохион байгууллаа.<br>2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Сайн дурын даатгалд малчин 2594, хувиараа хөдөлмөр эрхлэгч 575 иргэн, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 227, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг/эх 56 нийт 3452 иргэн тус тус хамрагдлаа. | - | 100 |
| 39 | 3.3.1.2. | Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | 95 | | УТ | Нийгмийн даатгалын байгууллага 2024 онд нийт тэтгэвэр авагчийн хувийн хэргийн 85 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, 2025 оны 11-р сарын байдлаар 95 хувьд хүргэсэн байна. Цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг оны эцэст бүрэн хэрэгжүүлж дуусгахаар ажиллаж байна. | - | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | 3.3.1.3. | Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх; | 1,835,146.2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо - 848 | - | 68 ажил олгогч авлагатай байна. | 1,784,913.0 | УТ | 2025 оны 01 сарын 01-ны өдрийн байдлаар нийт төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагуудын 3141,69 сая төгрөгийн шимтгэлийн авлагатай байснаас жилийн эцсийн байдлаар оны эхний авлагаас 143 ажил олгогчийн 708,52 сая төгрөгийн авлага буюу 22,55 хувийг барагдуулсан. Оны эхэнд 35 төсөвт байгууллагын 423,37 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай байснаас жилийн эцсээр бүрэн барагдуулсан боловч 18 ажил олгогчийн 173,24 сая төгрөгийн шимтгэлийн урсгал авлага шинээр үүссэн. **2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 68 ажил олгогч** 3123,8 сая төгрөгийн шимтгэлийн авлагатай гарахаар байна. Орон нутгийн төсвийн орлого тасарч, төсвийн хүндрэл үүссэн мөн эрүүл мэндийн ерөнхий газраас эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэлээр олгох санхүүжилт дутуу орж байгаа нь төсөвт байгууллагын урсгал өр авлага үүсэх үндсэн шалтгаан болсон. Төсөвт байгууллагатай холбоотой үүссэн шимтгэлийн урсгал өр авлагыг дараа оны 1 дүгээр улиралд бүрэн барагдуулах боломжтой. | | 50 |
| 41 | 3.3.1.4. | Хэгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах; | | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо | Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алсан иргэдийн тоо 102446 | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна. | 2240 | | УТ | 2025 оны эхэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон 2226 иргэн байсан бол жилийн эцсийн байдлаар 2240 иргэн байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 35 удаа хуралдаж 270 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоож, 810 иргэнийг сунгаж, 210 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, нийт 2240 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг шийдвэрлэлээ. Энэ нь гэмтэл хавдар ихсэж байгаатай холбоотой байна.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эмч нарын болон сувилагч нарын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж хүн амын өвчлөл, нас баралт, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар судалсан 30 гаруй илтгэл хэлэлцүүллээ. Аймгийн Засаг даргын захирамжаар 2025 оныг Эрүүл мэндийн жил болгон зарлалаа. 2025 онд эрүүл мэндийн салбарт нийт 7,279.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Явуулын амбулаторийн 2 автомашин нийлүүлж, эрчүүдийн үзлэгийг 9 сумд зохион байгуулж 765 хүн, явуулын эмнэлгийн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд зорилтот бүлгийн 5000 хүний 4964 буюу 99.2 %-ийг хамруулж, 2025 онд 18 сумын 60 багийн эмч (автомашинаар хангасан 46, гардуулахаар хүлээгдэж байгаа 14) нийт 950.0 сая төгрөгийн Probox автомашинаар хангаж, 1,612.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүллээ. Хорт хавдрын урьдал, хавдрын сэжигтэй болон үүсгэвэртэй 61 хүнийг илрүүлж лавлагаа шатлалд онош тодруулахаар илгээлээ. | | 100 |
| 42 | 3.3.1.5. | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна. | - | | - | Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн байгууллагуудаас орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлтэй, шаардлага хангасан төрийн албан хаагчдын материалыг журмын дагуу хүлээн авч, 12 сард дэмжлэгийг олгохоор ажиллаж байна. | | 100 |
| | | **НИЙТ** | | | | | | **1,784,913.0** | | | | |

**3.3.2. Нийгмийн халамжийн талаар:**

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | 3.3.3.2. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | 1,304,664.2 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 20 | сургалт зохион байгуулсан | | | Аймгийн Бугат, Эрдэнэ сумдад нөхөн сонгууль болохтой холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл судалгаа, сургалтын төвөөс нэгдсэн сургалт зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн сонгууль өгөхөд анхаарч ажиллах талаар заавар зөвлөмж өглөө. Үүний дагуу сонгууль өгөх өдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэн сонгууль өгөх боломж нөхцлөөр бүрэн хангаж, орж гарах зам налуу байх, сандал, томруулдаг шил бариул хавтас гэх мэт зүйлүүдийг хэсгийн хороод бэлтгэлээ. Иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх мэдлэг олгох ажлын хүрээнд "Хариуцлагатай сонгогч" сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 25 сурагч хамрагдлаа. Аймгийн сонгуулийн хорооны цахим хуудсаар иргэдэд мэдээллийг тогтмол хүргэлээ. | | 100 |
| 48 | 3.3.3.3. | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах; | | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 3 | 3сургалт | - | - | 2024 онд бэлтгэгдсэн сургагч багш нараар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй 43 иргэнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн үйлчилгээ" сэдвээр мэдээлэл хүргэлээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны хүүхэд, тэдгээрийн асран хамгаалагч 78 хүнд "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" сэдвээр гарын авлага бэлтгэн тарааж мэдээлэл өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрөөр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийхээр төлөвлөсөн. | | 100 |
| 49 | 3.3.3.4. | Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Дэмжих төв | - | 1 | ХБИ байртай болсон | | | Есөнбулаг сумын сургууль, цэцэрлэгийн тусгай хэрэгцээт хүүхдийн "Хүүхэд хөгжлийн төв"-ийн үйл ажиллагаатай танилцан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс,сургууль,цэцэрлэгийн багш ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.Тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажилладаг 7 багшид хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдээллийг хүргэн ажиллалаа. Хөхморьт, Баян-уул, Бигэр, Цогт сумдын тусгай хэрэгцээт хүүхдийн "Хүүхэд хөгжлийн төв"-ийн багш ажилтан нарт цахим сургалт зохион байгуулан хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдээлэл,нийгмийн халамжийн сангаас олгодож буй тэтгэвэр,тэтгэмж,тусламж,хөнгөлөлтийн талаарх мэдээллийг тус тус хүргэлээ. Мөн "Хан-Алтай ресурс" ХХК-ын 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 өрөөг засварлаж, аймгийн ажлын хэсэг засварын ажилтай үзэж танилцан хүлээн авлаа. | | 100 |
| 50 | 3.3.3.5. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 2 | 16 удаа хуралдсан | 2,000.0 | ОНТ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 16 удаа хуралдаж, 175 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааны асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс: шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоолгосон 11 хүүхэд, шинээр байнгын асаргаанд байх шаардлагатайг тогтоолгосон 27 хүүхэд, байнгын асаргааны хугацааг сунгуулсан 100 хүүхэд, буцсан 14 хүүхэд байна. Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын гишүүдийг чадавхжулах сургалтад 5 хүнийг хамруулж, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | | 100 |
| 51 | 3.3.3.6. | Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100 | зөвлөмж, мэдээллийг тогтмол хүргэж байна. | | - | Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг 60 удаа зохион байгуулж, 8991 иргэн хамрагдсан. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хангах талаар зөвлөмж, мэдээллийг тогтмол хүргэж байна. Гамшгийн үед сургуулийн биеийн тамирын заалыг хоргодох байраар ажиллуулахаар төлөвлөсөн. Мөн шинээр баригдсан барилгын подволыг хоргодох байраар ажиллуулахаар төлөвлөсөн. Энэ онд шинээр 19 барилга ашиглалтад орсон. | | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 3.3.3.7. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5 | 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан. | 3,200.0 | ОНТ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, хүүхдүүдийг нарийн мэргэжлийн үзлэг оношлогоо, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах зорилгоор "Бэрхшээлийг боломж болгоё" нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн "Зөвлөх баг", "Ээлтэй хүүхэд" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд давхардсан тоогоор 178 хүүхдийг хамруулж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 40 хүүхэд, 21 эцэг эхчүүд, чадавхжуулах сургалтад 180 иргэнийг хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрийн үзлэгийн зохион байгуулж, давхардсан тоогоор 180 хүүхэд хамрагдаж, эцэг эхэд нь зөвлөгөө мэдээлэл өглөө. Засагт хан хот айл зусланг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, 390 хүүхэд хамрагдсанаас хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамрууллаа. | 100 |
| 53 | 3.3.3.8. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо | - | 3 | 108.7 сая төгрөг төвлөрүүлсэн | | - | Аймгийн хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 77 аж ахуйн нэгж, байгууллага байна. Дээрх байгууллагуудад 148 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 168 ХБИргэн ажиллаж, 16 байгууллага 21 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаар байна. Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хүрээнд хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч 17 аж ахуйн нэгж, байгууллагад 153.4 сая төгрөгийн ажлын байрны төлбөрийн актыг хүргүүлснээс 3 байгууллагаас 108.7 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүллээ. | 100 |
| 54 | 3.3.3.9. | Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо | - | 5 | цахимаар мэдээ мэдээлэл хүргэж байна. | | - | Аймгийн ЗДТГ болон төрийн байгууллагуудын цахим хуудсаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тус аймгийн орон нутгийн "Алтай" телевиз, "Миний нутаг" сошиал телевиз, олон нийтийн "Алтай" радио, "Монцамэ-Говь-Алтай" сайт болон "Алтайн мэдээ агентлаг" пейж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хуулийн хэрэгжилтийн болон бусад мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж байна. Мөн "Хан-Алтай ресурс" ХХК-ын 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2 өрөөг засварлаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлд хүлээлгэн өгч, үйл ажиллагаагаа явуулан мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна.Аймгийн цахим үйлчилгээний хэлтсээс иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, цахим зөв соёлыг дэлгэрүүлэх, үнэн бодит мэдээллийг түгээх чиглэлээр олон үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. | 100 |
| 55 | 3.3.3.10. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | - | төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. | 5,400.0 | ОНТ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 16 удаа хуралдаж, 175 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааны асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс: шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоолгосон 11 хүүхэд, шинээр байнгын асаргаанд байх шаардлагатайг тогтоолгосон 27 хүүхэд, байнгын асаргааны хугацааг сунгуулсан 100 хүүхэд, буцсан 14 хүүхэд байна. Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын гишүүдийг чадавхжулах сургалтад 5 хүнийг хамруулж, аймгийн Засаг даргын Тамгын газраас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагддаг "Монгол Абилимп 2025" ур чадварын уралдаан тэмцээнд оролцсон иргэдийн төлөөлөлд 1.4 сая төгрөг, Архангай аймагт зохион байгуулагдсан үндэсний "Пара-спорт2025" улсын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнд оролцогчдод 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. | 100 |
| 56 | 3.3.3.11 | Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо. Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв | - | 3 | налуу шаттай 34, ариун цэврийн өрөөтэй 6 | | | Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандандартад нийцсэн налуу шаттай 34, тусгайлан тоноглосон ариун цэврийн өрөөтэй 6 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд хүртээмжтэй, саадгүй орж гарах нөхцлийг сайжруулах чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлснээр шинээр баригдсан 19 байгууллага гадна талынхаа налуу замыг стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэлээ. | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 3.3.3.12 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах. | - | Хөгжлийн төвийн тоо | - | 1 | хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөл байртай болсон. | 35,000.00 | хувийн хэвшил | "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын хуучин байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 өрөөг "Хан-Алтай ресурс' ХХК-ын 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр засварлаж, аймгийн ажлын хэсэг засварын ажилтай үзэж танилцан хүлээн авлаа. Тус өрөөнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлд хүлээлгэн өгч, үйл ажиллагаагаа явуулан мэдээ мэдээллийг тогтмол хүргэх байна. | | 100 |
| | **НИЙТ** | | | | | | | **47,600.0** | | | | |
| **3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:** | | | | | | | | | | | | |
| 58 | 3.3.4.1 | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Сургалт, мэдээллийн тоо 2.Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо | - | 5-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. | 68 | 102,600.0 | УТ 10,000.0 ОНТ 92,600.0 | Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" буцалтгүй тусламжаар баригдсан "Түр хамгаалах байр"-ыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, аймгийн Засаг даргын 2025 оны А/44 тоот захирамжаар бүтэц орон тоог 5-аар батлан, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт тусган, үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Энэ оны эхний 11 сарын байдлаар хүүхэд 25, насанд хүрэгч 7, нийт 32 хүнийг аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээ үзүүлэн, хохирогчийг гэр бүлд нь эргэн нэгтгэж ажиллалаа. Түр хамгаалах байранд орон нутгийн төсвөөс 119.0 сая төгрөг шийдвэрлэсэн. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-ийн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хүүхэд 91, насанд хүрэгч 62 нийт 153 хүнийг хамруулсан. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх 26 удаагийн албадан сургалтад 100 иргэнийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 68 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 3470 хүнийг хамрууллаа. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 2500 гэр бүл, 9792 иргэнийг хамруулсан нь нийт өрхийн 15.2%-ийг эзэлж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт нэгдэж, гэр бүлийн болон охид эмэгтэйчүүдийг эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл өгч, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгууллаа. | | 100 |
| | **НИЙТ** | | | | | | | **102,600.0** | | | | |
| **3.3.5. Ахмад настны талаар:** | | | | | | | | | | | | |
| 59 | 3.3.5.1 | Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2 | - | Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг, мэдээлэл сайжирсан байна. | 932 иргэн | | - | "Ахмад настны тухай" хууль болон холбогдох хуулиуд тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр баталсан тогтоол, журмын талаарх сургалтыг аймаг, сумдын ахмадын хороос болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 450 иргэнд зохион байгууллаа. Сургалтын үеэр иргэд, олон нийтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийгмийн халамжийн үйлчилгээний гарын авлага, брошурыг тарааж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа. Энэ оны 11 сард "Хууль сурталчлах аян"-ы хүрээнд 24 аж ахуйн нэгж, байгууллагын 482 хүнд сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өглөө | | 100 |
| 60 | 3.3.5.2 | Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо | Ахмадын сан байгуулсан ААНБ-ын тоо, тэтгэвэр бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ААНБ-ын тоо | ААНБ-ын 50-аас дээш хувь ахмадын сан байгуулсан байна. | ахмадын сан -16 байгууллага, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө-12 байгууллага | | - | Аймаг дахь Төрийн аудитын газраас "Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хуулийн хэрэгжилт, үр дүн"-д нийцлийн аудит хийгдэж, зөвлөмж ирүүлсэн. Тус зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилт 100% байна. Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 3/1427 албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах үүрэг чиглэлийг хүргүүллээ. Зөвлөмжийн мөрөөр сум байгууллагын дарга нарт ахмадын сан байгуулж ажиллах үүрэг, чиглэлийг албан бичгээр болон хурал, сургалтад оролцоход нь өгсөн. Мөн ахмадын сан байгуулан ажиллуулах журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мэдээлэл сургалтыг 40 төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтэд зохион байгуулж, 2800 иргэнийг хамрууллаа. Аймгийн ахмадын хороо сумдын ахмадын хороогоор дамжуулан ахмадын сангийн данс нээх талаар мэдээлэл өгч, ХХҮГ "Хууль таны амьдралд" аян зохион байгуулж, аймгийн төвийн 24 байгууллагад ахмадын сангийн данс нээх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Ахмадын сан байгуулсан 11 байгууллага байна. Ахмадын сангийн данс нээлгэхээр хүсэлтээ аймгийн төрийн санд ирүүлсэн 6 байгууллага байна. Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлж буй 12 байгууллага байна. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | 3.3.5.3. | Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо | Нийт ахмадын 60% | 20 -оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна. | 150.1 сая т | 1 0,100.0 | ОНТ | Аймгийн ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 150,1 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллалаа. Аймагт ахмадын сувилал баригдаж байгаа ба барилгын явцын ажил 50%-тай байна. "Ахмадаа хүндэлье" өдөрлөгт 92, аймгийн ахмадын спортын бага наадамд 5 төрлөөр 620, ахмад настны эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээнд 677 ахмад хамрагдлаа.Ахмад настнуудын дунд 7 хоног бүр нийтийн бүжиг зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1002, өглөөний дасгал хөдөлгөөнд давхардсан тоогоор 2840 ахмад тус тус хамрагдаж байна. | | 100 |
| 62 | 3.3.5.4. | Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан тоо | - | Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. | давхардсан тоогоор 5231 ахмад хамрагдсан | 3 000.0 | УТ | "Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ"-ний тендерийн сонгон шалгаруулалтыг зарлаж, "Даши-Асаагч" ХХК нь шалгарч гэрээ байгуулж тайлант хугацаанд 6 төрлийн үйлчилгээнд 677 ахмадад үйлчилгээ үзүүлээд байна. "Ахмадаа хүндэлье" өдөрлөгт 92, аймгийн ахмадын спортын бага наадамд 5 төрлөөр 620, Ахмад настнуудын дунд 7 хоног бүр нийтийн бүжиг зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1002, өглөөний дасгал хөдөлгөөнд давхардсан тоогоор 2840 ахмад тус тус хамрагдаж байна. | | 100 |
| 63 | 3.3.5.5. | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо | - | Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна. | 4337 ахмад буюу 65.7% | | - | "Ахмад настанд цогц үнэлгээ хийх" ажлыг ХХҮГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран зохион байгуулж, ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээнд 4337 ахмад хамруулլаа. | | 100 |
| 64 | 3.3.5.6. | Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо | - | Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж сайжирсан байна. | 100% | 3 000.0 | УТ | Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны А/401 дүгээр захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хамтарсан багийг байгуулан ажиллалаа. Ахмад настны цогц үйлчилгээ үзүүлэх гэрээг "Даший-Асаагч" ХХК-тай байгуулан ажиллаж, 677 ахмад настанд үйлчилгээ үзүүллээ. "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлэг, явуулын эмнэлгийн үйлчилгээнд 458, нийт дээрх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 7646 ахмад настан хамрагдлаа. Эрүүл мэндийн төвүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 4462 ахмад хамрагдаж, гэрийн эргэлтийг 1106 ахмадад хийснээр нийт 5568 буюу 84.4 хувьд эрүүл мэндийн тусламж үзүүлсэн байна. | | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 3.3.5.7. | Ахмад настанаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо<br>2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо | - | Ахмад настанаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | 5 удаагийн сургалт | 62 640,0 | ХЭДСан | "Ахмад настны тухай" хууль болон холбогдох хуулиуд тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр баталсан тогтоол, журмын талаарх сургалтыг аймаг, сумдын ахмадын хороо болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 450 иргэнд зохион байгууллаа. Угийн бичгийг дэлгэрүүлэх цус ойртолтоос сэргийлэхэд ахмадуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ХГБХХГ, ХХҮГ, ахмадын хороо хамтран 5 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 82 ахмадыг хамрууллаа. Дэлгэр сумын Баянсан багийн төлөөлөл Д.Хүрэлбаатарын гэр бүл угийн бичгээ хөтөлдөг арга туршлагаасаа залуу гэр бүлүүдэд танилцуулж, Дэлгэр сумын Соёлын төвийн номын санч өвлөн уламжлагч Я.Чоижин гэр бүлийн хамт Монголын Үндэсний олон нийтийн телевизийн 600 студийн "Мэнд амар байна уу" контент нэвтрүүлэгт оролцож уламжлалт өв соёлын нэгэн төрөл болох сур харваа, эсгий урлалыг сурталчлан оролцлоо. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, спортын чиглэлээр зохион байгуулж, 15 сум 1 тосгоны 58 ахмадыг хамруулж, ХЭДСангаас 62.6 сая төгрөг зарцууллаа. | | 100 |
| 66 | 3.3.5.8. | Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Журам баталсан эсэх<br>2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/ | - | Журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Ганц бие орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна. | | | | "Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ыг боловсруулан сумдын Засаг дарга, тамгын дарга, нийгмийн бодлогын болон хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг тусган аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Уг журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 09-р хуралдаанаар батлууллаа. | | 100 |
| 67 | 3.3.5.9. | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна." гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих; | - | 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо | Суурь түвшний тоо | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 935 иргэнд мэдээлэл өгсөн. | | - | "Хөдөлмөрөөр өөрчлөлтийг эхлүүлцгээе", "Хуульчийн про боно-2025", өдөрлөгийн үеэр "Ахмад настны тухай" хууль, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх заалт болон "Ахмад настны тухай" хууль, холбогдох хуулиуд тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр баталсан тогтоол, журмын талаарх сургалтыг аймаг, сумдын ахмадын хороо болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 450 иргэнд зохион байгууллаа. Сургалтын үеэр иргэд, олон нийтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийгмийн халамжийн үйлчилгээний гарын авлага, брошурыг тарааж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч ажиллалаа. Энэ оны 11 сард "Хууль сурталчлах аян"-ы хүрээнд 24 аж ахуйн нэгж, байгууллагын 482 хүнд сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өглөө. | | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 68 | 3.3.5.10 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо | - | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна. | | | | Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан тендэр шалгаруулалтад тэнцсэн компанийг хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээг нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг чиглэл болгон ажиллаж байна. | | - |
| | | **НИЙТ** | | | | | | **282,740.0** | | | | |

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д БУЯНХИШИГ

ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.АМГАЛАНБААТАР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.АРИУНТУЯА